



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2026.02.03 № 07

Малчны тухай хуулийн хэрэгжилтийн
талаар

Монгол Улсын Их Хурлаас 2024 оны 06 дугаар сард Малчны тухай хуулийг батлан 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн. Энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх хэсэгт “хуульд заасан өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй малчны тэтгэврийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх”, мөн зүйлийн 4.3 дахь хэсэгт “Энэ хуулийн ..., 4.2.9-д заасан арга хэмжээтэй холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан журмаар зохицуулна”, 16 дугаар зүйлийн 16.1-д “Энэ хуулийн 4.2.9 дэх заалтыг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан.

Хуулийн хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд Засгийн газраас уг журмыг батлуулаагүй байх тул Монгол Улсын Ерөнхий сайд Танд дараах асуулгыг тавьж байна.

1. Малчны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.9 дэх заалтыг хэрэгжүүлэх хугацаа нэгэнт дууссан. Хуулийн энэ заалтыг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ байгаа эсэх, хэрэв байгаа бол ямар ажил хийсэн, хэрхэн гүйцэтгэсэн, түүний үр дүнгийн талаар;

2. Засгийн газраас журам батлаагүй, хууль хэрэгжүүлээгүй шалтгаан нөхцөлийн талаарх мэдээллийг ирүүлж, уг асуудлыг хариуцсан албан тушаалтанд хариуцлага тооцох эсэх асуудлаар дэлгэрэнгүй мэдээлэл;

3. Малчин өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй бол нийгмийн даатгалын шимтгэлийг нэг удаа нөхөн төлүүлэх асуудлаарх Засгийн газрын байр суурь болон хуулийн биелэлтийг хангахтай холбоотой цаашид энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар төлөвлөгөө гаргасан эсэх;

4. Засгийн газрын буруутай үйл ажиллагаанаас хэрэгжээгүй Малчны тухай хуулийн уг заалтыг хэрэгжүүлэх хугацааг сунгахтай холбогдуулан хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн барих эсэх, өргөн барих хугацааны талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Дээрх асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

О.АЛТАНГЭРЭЛ



2026000019